МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
http://www.mmhi.gov.mn

2020.01.20 № 01/155

танай 2019.12.17 -ны № 5-2/8252 -т

САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан хүргүүлэх тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл дэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл дэх тус яамны дангаар хэрэгжүүлэх 5 арга хэмжээ, 17 шалгуур үзүүлэлт, хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээ, 8 шалгуур үзүүлэлтийн биелэлт нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 83.0 хувийн хэрэгжилттэй байна.

1. УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2020.01.20-ны өдрийн хурлын тэмдэглэл 1 хуудас;
2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, хавсралтын хамт 36 хуудас.

Хавсралт 37 хуудастай.

Д.СУМЪЯАБАЗАР

D/УУХҮЯ Сайд А4
С8 0073

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2020 оны 01 сарын 20 өдөр Дугаар 02. Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Н.Баатар хийв

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж Сангийн яаманд хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

08 0027

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь Улсын Их Хурлын 2018 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл дэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт тус бүрээр нь хяналтанд авч, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, шийдвэр гаргах түвшний удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 20 зорилт тусгагдсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь "Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого"-ын "Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ." **5 дахь зорилтын 5 арга хэмжээ, 17 шалгуур үзүүлэлтийг "дангаар"**, "Эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ." 6 дахь зорилтын 2 арга хэмжээ, 6 шалгуур үзүүлэлт, "Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого"-ын "Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангана." 8 дахь зорилтын 2 арга хэмжээ, **2** шалгуур үзүүлэлт буюу **2 зорилтын 4 арга хэмжээ, 8 шалгуур үзүүлэлтийг "хамтран"** хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг тус тус удирдлага болгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-ны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын тайлагнасан биелэлтэнд өгсөн үнэлгээнд дүгнэлт, зөвлөмж боловсруулсан (хавсралт 1, 2).

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тус яамны "дангаар" хэрэгжүүлсэн 1 зорилтын 5 арга хэмжээ, 17 шалгуур үзүүлэлт, "хамтран" хэрэгжүүлсэн 2 зорилтын 4 арга хэмжээ, 8 шалгуур үзүүлэлт буюу 3 зорилтын 9 арга хэмжээ, 25 шалгуур үзүүлэлтийн биелэлт **83.0**

**хувьтай**, үүнээс 12 шалгуур үзүүлэлт нь 100 хувь, 6 шалгуур үзүүлэлт нь 70 хувь, 1 шалгуур үзүүлэлт нь 40 хувь, 1 шалгуур үзүүлэлт нь 0 хувийн хэрэгжилттэй, "үнэлгээ өгөх боломжгүй" 5 шалгуур үзүүлэлт байна. (Хүснэгт 1)

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 1

| Дугаар | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Арга хэмжээний биелэлт, хувиар | | | | | Биелэлт /хувиар/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 40 | 0 | /-/ | | |
| 1 | 3 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО | | | | | | | | | |
| Зорилт 5.Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. | | | | | | | | | |
| 5,1 | Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх | 4 | 3 | 0 | 0 | 1 | 0 | 75,00 | Дангаар хэрэг жүүлэх |
| 5,2 | Нутаг дэвсгэрийн ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах, геоэкологи, гидрогеологийн судалгаа хийх, геомэдээллийн санг баяжуулах сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэх | 6 | 6 | 0 | 0 | 0 | 0 | 100,00 | |
| 5,3 | Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | 2 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 85,00 | |
| 5.4. | Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх | 4 | 1 | 3 | 0 | 0 | 0 | 77,50 | |
| 5,5 | Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлэх | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100,00 | |
| | **Зорилт 5-ын дүн** | **17** | **12** | **4** | **0** | **1** | **0** | **87,05** | |
| Зорилт 6.Эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6,2 | Монгол Улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, Өмнөд бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах шинэ эх үүсвэр барих | 5 | 0 | 2 | 0 | 0 | 3 | 70,00 | Хамтран хэрэг жүүлэх |
| 6,3 | Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх | 1 | 0 | 0 | 0 | 0 | 1 | ./-/ | |
| | **Зорилт 5-ын дүн** | **6** | **0** | **2** | **0** | **0** | **4** | **70,00** | |
| ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО | | | | | | | | | |
| Зорилт 8.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангана. | | | | | | | | | |
| 8,1 | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулах | 1 | 0 | 0 | 0 | 0 | 1 | ./-/ | Хамтран хэрэг жүүлэх |
| 8,8 | Ган, төмөрлөг болон цементийн үйлдвэрлэлийг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох | 1 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 40,00 | |
| | **Зорилт 8-ын дүн** | **2** | **0** | **0** | **1** | **0** | **1** | **40,00** | |
| **Үндсэн чиглэлийн арга хэмжээний тоо болон үнэлгээ, хувиар** | | **25** | **12** | **6** | **1** | **1** | **5** | **83,00** | |

Үндсэн чиглэлийн зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай; илүү сайн тодорхойлох шаардлагатай, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй; шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан дараахь 3 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

1. "Эрчимжүүлэх шаардлагатай" 40 хувийн биелэлттэй 1 шалгуур үзүүлэлт
   1.1. Ган, төмөрлөг болон цементийн үйлдвэрлэлийг дэмжих, бизнесийн таатай орчныг бий болгох

2. "Үр дүнгүй" 0 хувийн биелэлттэй 1 шалгуур үзүүлэлт
   2.1. Агаарын геофизикийн судалгааны ажлын хүрээнд Ховд-1 төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар

3. "Үнэлэх боломжгүй" 5 шалгуур үзүүлэлт нь тус яамны "хамтран" хэрэгжүүлэх арга хэмжээ байна
   3.1. Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц барих төслийн санхүүгийн хаалт хийх ажлын явц, хувиар
   3.2. Багануурын 700 МВт-ын ДЦС барих төслийн барилгын ажлын явц, хувиар
   3.3. Баруун бүсийн 60 МВт-ын ДЦС-ын барилгын ажлын явц, хувиар

3.4. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлэх

3.5. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 зорилтын 9 арга хэмжээний 25 шалгуур үзүүлэлт нь 83.0 хувьтай үнэлэгдэв.
2. Геологийн судалгааны ажлуудаар геологийн тогтцын ямар асуудлуудыг шийдсэн, өмнөх шатны судалгаагаар тогтоогдсон үнэт металл, холимог металл, металл бус ашигт малтмал, барилгын материалын, шатах ашигт малтмал, ундрах усны хэдэн илрэл, эрдэсжсэн цэг, геохимийн гажил, геофизикийн гажлыг баталгаажуулсан, шинээр тогтоосон, баталгаажуулаагүй, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээг өснөөр Монгол орны эрдэс баялгийн хэмжээг нэмэгдүүлсэн, хэдэн аймгийн нутаг дэвсгэр дэх түүхэн дурсгалт газар, олдворыг нэгтгэн, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байдал зэргийг биелэлтэнд огт дурдахгүй байдал үргэлжилж, геологийн судалгааны ажлын үр дүн, үр өгөөжийг олон нийтэд таниулах талаар санаачлагатай ажиллахгүй байна.
3. Ашигт малтмал олборлон баяжуулах үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр нь тасралтгүй, удаан хугацаанд ажиллахад шаардлагатай түүхий эдийн нөөцийг бэлтгэх геологийн судалгааны ажлыг эрчимжүүлэх, хүнд үйлдвэрээ дагасан бүтээн байгуулалтын өмнөх тухайн нутаг дэвсгэрийн цэвдэгшил, газрын гүн дэх хөндийлж, ундны болон үйлдвэржилтийн усан хангамжийн нөөцийг тогтоох инженер геологи, геоэкологи, гидрогеологийн судалгаа, барьж байгуулах үйлдвэрийн хүчин чадал, техник технологи зэрэг мэргэжлийн дүгнэлтийг бодлогын түвшинд анхаарахгүй орхигдуулсан байдалд ахиц өөрчлөлт гарахгүй байна.
4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөлтийн дүн, Улсын Их Хурлын тогтоолоор баталсан төсвийн дүн зөрүүтэй байна.
5. Мэргэжлийн газар, хэлтсүүд хамтран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг анхаарахгүй орхигдуулж биелэлтийг тайлагнахгүй байна.
6. Стратегийн бодлого төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын чиг үүрэг давхцалтайн улмаас хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын хэсэгт ажилласан Стратегийн бодлого төлөвлөлтийн нэгжийн албан хаагчид биелэлтийг тайлагнахгүй байгаагаас тус яамны хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг тайлагнахгүй байх талтай байна.
7. ХШҮДАГ-ын геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын ХШҮ хариуцсан албан хаагчид нь газар хэлтсүүдийн тайлагнасан биелэлтэнд “хэрэгжилтийн хувь”-ийн **“үнэлгээ”** өгөхөөр хязгаарлаж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд

хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж "**хяналт шинжилгээ**" хийхгүй байдал давтагдсаар байна.

8. ХШҮДАГ нь хүн хүч дутмаг, ХШҮ-ний ажлыг анхаардаггүйн улмаас бодлогын зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй, зорилтот түвшинд хүрээгүй шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагаа хэрэгжихгүй байна.
9. Яам, агентлагийн мэргэжлийн зарим газар, хэлтсүүд нь хариуцсан асуудлаар тооцоо судалгаа, нэгтгэл, дүн шинжилгээ хийхгүй, албан хэрэгцээнд шаардлагатай материалууд байхгүй, тайланг 2000 тэмдэгтэд багтаах, дэлгэрэнгүй тайланг танилцуулга хэлбэрээр хавсаргаж, хагас жилийн биелэлтээс хойшхи нотлох баримтуудыг хавсаргаагүй, геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын ХШҮ хариуцсан албан хаагчид нь эдгээрийг бүрдүүлэх талаар анхаарахгүй орхигдуулсан.

## ТАВ. ЗӨВЛӨМЖ.

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу зорилтот түвшин, баримт нотолгоо, зарцуулсан хөрөнгөний гүйцэтгэлд үндэслэн хүрсэн үр дүн, ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд мэргэжлийн өндөр түвшинд анхаарч, тайлан, мэдээг хугацаанд нь үнэн бодит тайлагнаж хэвших шаардлагатай байна.

2. Улсын Их Хурал, Засгийн газарт батлагдахын өмнөх хэлэлцүүлэг, хамгаалалтанд бодлогын баримт бичгийн төслийг гардан боловсруулсан албан хаагчдыг оролцуулах шаардлагатай байна.

3. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хэтийн болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн үндсэн чиглэлийг боловсруулах шаардлагатай байна.

4. ХШҮДАГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчид нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 2.1.1 дэх байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Хавсралт:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан (Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам), 2019 оны эхний хагас жилийн байдлаар, 17 хуудас,

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зарцуулсан хөрөнгө төсвийн гүйцэтгэлийн нэгтгэл, 8 хуудас,
3. Дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй арга хэмжээний тайлбар дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй арга хэмжээний тайлбар, 8 хуудас,

Нийт 33 хуудас

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

2020 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр

Хянасан: ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү

Нэгтгэл хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан:
ХШҮДАГ-ын ахлах шинжээч Н.Баатар /2020.01.19/

Геологи, уул уурхайн салбарын биелэлтэд үнэлгээ өгсөн:
ХШҮДАГ-ын мэргэжилтэн Д.Батнайрамдал

Хүнд үйлдвэр, газрын тосны салбарын биелэлтэд үнэлгээ өгсөн:
ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Болортуяа

Хавсралт .....

# УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр | 2019 оны жилийн эцсийн байдлаар Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО | | | | | | | |
| Зорилт 5.Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. | | | | | | | |
| 5.1 | МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид "ТЭБСББ" гэх/-ын 3.2.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.59-2.61 дэх заалт | Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх | 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар | 43.5 | 7.1 Улсын төсөв | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Бурхант толгой-50, Дэвсгийн нуруу-50, Улаан толгой-50, Хулгарын элс-50, Суман хад-50, Хайлааст уул-50, Чандмань уул-50, Өлийн овоот-50 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2019 оны 11, 110, 111, 116, 125, 126, 127, 138 дугаар тушаалаар хүлээн авсан. Дээрх 8 төслийг хэрэгжүүлснээр 35,549.7 кв.км талбай буюу 2.3%-ийг бүрэн хамруулсан ба нийт нутаг дэвсгэрийн 40.5%-ийг бүрхээд байна. Эдгээр талбайд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар бүрхсэнээр тухайн талбайд тархсан төрөл бүрийн хурдас чулуулгийн тархалт, хил зааг, нас, найрлага зэргийг тодорхойлон зурагласан бөгөөд ашигт малтмалын хэтийн төлөвийг тодруулж, хэтийн төлөвтэй талбайг ялгасан. | 100 |

заалт

Эдгээр талбайнууд нь хуулиар хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайнууд юм. 2019 онд энэ төрлийн 31 төслийг нутаг дэвсгэрийн 4.2%-д хэрэгжүүлэн ажиллахаар төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А13 дугаар тушаалаар батлан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2019 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2019.05.03-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар баталсан. Мөн 2019 онд шинээр Хулд-50, Халзан-Овоо-50, Алаг баян-50, Өндөрширээт-50, Оорцог уул-50, Хайрхан-Овоо-50, Ширээт уул-50, Борзонгийн говь-50, Гилбэнт уул-50, Зангат-50, нийт 10 төслийг шинээр хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулалтыг 2019.03.25, 2019.04.09-нд цахимаар зарлан тендерт шалгарсан гүйцэтгэгч нартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан.

Төслүүдийн 2019 оны суурин болон хээрийн судалгааны анхдагч материал хүлээн авах төлөвлөгөө, төсвийг ТНБД-ын 2019.05.29-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар баталсан. Төслүүдийн 2019 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын анхдагч материалыг 2019.10.20-11.15-ны өдрүүдэд хүлээн авсан. Энэхүү ажилд 2019 онд 6.27 тэрбум төгрөг зарцуулахаар батлуулж, санхүүжилтийг олгосон.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Улсын геологийн иж бүрдэл зургийг "К" хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлын явц, хувиар | 50 | Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд 2016-2020 онд нэгтгэх төслийн 2019 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлан К хавтгайн 35%-д буюу баруун хэсэгт хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар хээрийн судалгааны ажлыг 100% дуусгасан. Мөн 2019 оны хээрийн болон суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн 2019.03.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж УУХҮС-ын 2019.05.03-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан.<br>Монгол орны L хавтгайн хэмжээнд иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг 2019 онд эхлүүлэхээр УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар төлөвлөгөө, төсвийг баталсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр баталсан. Төслийн ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй гэрээг байгуулсан. L хавтгай нь нийт нутаг дэвсгэрийн 839,481.26 кв.км буюу 53.7%-ийг эзлэх бөгөөд төлөвлөгөөт онд L хавтгайн 15 хувьд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Дээрх 2 төслийн хээрийн судалгааны ажлын анхдагч баримт материалыг хүлээн авсан.<br>Улсын геологийн иж бүрдэл зургийг К, L хавтгайн хэмжээнд нэгтгэх ажилд 2019 онд 755,317,614.0 төгрөг батлуулж, санхүүжилтийг бүрэн олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Агаарын геофизикийн судалгааны ажлын хүрээнд Ховд-1 төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар | 20 | | Монгол орны баруун хэсэг буюу 104,044.0 кв.км талбай /6.6%/-г хамарсан агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгийн судалгааны ажлыг 2019 онд хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр, УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг тус тус батлуулсан. Энэхүү Ховд-2019 (Ховд-1) төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2019.03.25-ны өдөр цахимаар зохион байгуулсан хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангасан хуулийн этгээд шалгараагүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт 2019.06.01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан зөвлөхийг сонгох тендерийг 2 удаа зарласан ч амжилтгүй болсон. Төслийг 2020 оноос дахин хэрэгжүүлэхээр УУХҮС-ын 2020 оны төсвийн багцад санхүүжилтийн эх үүсвэрийг тусгуулсан. | 0 |
| | | | Монгол орны геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлын явц, хувиар | 20 | | Монгол орны нутаг дэвсгэрийн 1,149,529.0 кв.км талбай /73.5%/-г хамарсан 1:1000000-ны масштабын геохимийн зураглал хийх, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны ажлыг 2019 онд хэрэгжүүлэхээр УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг батлуулсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг боловсруулан ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Геохими-2019 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2019.03.25-ны өдөр цахимаар зохион байгуулж гүйцэтгэгч хуулийн этгээдийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг гүйцэтгэгч ААН-тай байгуулсан.Төлөвлөгөөт онд Монгол орны баруун, баруун өмнөд, зүүн өмнөд хэсэгт буюу К-48-А,Б, К-47-Б, L-48-А,Б,В,Г, L-49-А,Б,В, L-46-А,Б, L-47-А,Б,В,Г хавтгайд дээжлэлтийн ажлыг хийж нийт 1167 ширхэг дээжлэлт хийсэн. Ингэснээр нийт талбайн 31.3%-д хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. 2019 онд 667,845,354.0 төгрөг батлуулж, санхүүжилтийг бүрэн олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2 | МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, ТЭБСББ-ын 3.2.2 дахь заалт ЗГҮАХ-ийн 2.59-2.61 дэх заалт | Нутаг дэвсгэрийн ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах, геоэкологи, гидрогеологийн судалгаа хийх, геомэдээллийн санг баяжуулах сэдэвчилсэн судалгааны ажлыг гүйцэтгэх | Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын тоо | 3 | 6.2 Улсын төсөв | 1. Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи-2017 төслийн 2019 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар тус тус баталсан. Төслийн 2019 оны суурин боловсруулалтын ажлын төсөл, төсөвт хийх тодотголыг ЭБМЗ-өөр 2019.02.21-ний өдөр хэлэлцэж, УУХҮС-ын 2019.05.03-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар батлан суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн.<br>2. Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2019 оноос хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар, судалгааны ажлын геологийн даалгаврыг ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр тус тус батлуулсан. Судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 2019.03.25-ны өдөр цахимаар зарлаж гүйцэтгэгч хуулийн этгээдийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Дээрх төслийн 2019 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан. Улаанбаатар болон Эрдэнэтийн төсөлд нийт 655,545,556.0 төгрөг зарцуулахаар төлөвлөж, санхүүжилтийг бүрэн олгосон. 3. Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2020 оноос хэрэгжүүлэхээр санхүүжилтийн эх үүсвэрийг Улсын төсөвт тусгуулан батлуулсан. | 100 |
| | | | Голлох ашигт малтмалын хэтийн төлвийн судалгааны ажлын тоо | 1 | | Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлын 2019 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар баталсан. Судалгааны ажлын 2019 оны төсөл, төсвийн тодотголыг УУХҮС-ын 2019 оны А/98 дугаар тушаалаар батлуулж, хээрийн судалгааны ажлыг эхэлсэн. Төлөвлөгөөт онд хээрийн судалгааны ажлаар хэтийн төлөв бүхий 78 талбайд нарийвчилсан эрлийн ажил, 24 талбайд уул-өрөмдлөгийн ажил, 278 талбайд эрэл шалгалтын ажил хийхээр төлөвлөж хээрийн үйлдвэрлэлийн ажлыг 2019.04.15-ны өдрөөс эхлэн бүрэн дуусгасан. 2019 онд 13,997,257,773.0 төгрөгийн төсөв баталж, жилийн эцсийн байдлаар 12,752,332,702.0 төгрөгийн санхүүжилт олгосон. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| Алт-2 хөтөлбөрийн хүрээнд Монгол орны алтны хэтийн төлвийг тогтоох эрлийн ажилд хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар | 60 | Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын "ТЗМ-Алт-2017" төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2019 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр 2019.02.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2019.05.03-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар батлуулсан. Хээрийн судалгааны ажлыг 2017-2018 онд гүйцэтгэж дууссан бөгөөд МО-ны 521,200.0 кв.км талбай буюу 33.3%-д тархсан алтны хүдэржилт бүхий талбай, дүүрэг, зангилаа, түүнд тогтоогдсон орд, илрэл, эрдэсжсэн цэг, сарнилын хүрээ бүхий хэсгүүдийг 100% нарийвчлан судалсан. Хээрийн судалгааны ажлуудын анхдагч материал, лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэн төслийн үр дүнгийн тайланг 2020 оны 1-р улиралд багтаан ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төслийн 2019 оны төсвийг 1,043,113,994.0 төгрөгөөр батлуулан, санхүүжилтийг бүрэн олгосон. | 100 |
| | | 2019 оноос Монгол орны баруун, баруун өмнөд, хангайн бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны ажлыг БӨМ-Алт-2019 нэртэйгээр хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар батлуулсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг боловсруулан ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг цахимаар хийж, шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Уг төслийн төсвийг 2019 онд 575,680,221 төгрөгөөр батлуулан, санхүүжилтийг бүрэн олгосон. Төлөвлөгөөт оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан. | |

| | | | |
|---|---|---|---|
| Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах судалгааны ажлын тоо | 1 | Үндэсний геомэдээллийн санг Интрузив, эффузив, үнэмлэхүй насны мэдээллийг нэгтгэх, Давхарга зүй, палеонтологийн олдвор, горизонтын тулгуур зүсэлтийн мэдээллийг нэгтгэх, Хээрийн баримт материал, үр дүнгийн тайлангийн мэдээллийг цахимаар хүлээх авах, сан бүрдүүлэх аргачлал, үлгэрчилсэн загвар боловсруулах, багажны хэмжилтийн утгыг нарийвчлан гаргах, Бүх төрлийн масштабын геологийн зураг, давхаргын мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн загварт оруулах зорилгоор Геомэдээлэл-2019 төслийг хэрэгжүүлэхээр УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөө батлуулсан. Ажлын геологийн даалгаврыг ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар 2019.04.09-ний өдөр цахим тендерийг зохион байгуулж, хамгийн сайн үнэлэгдсэн оролцогчтой зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Уг төслийн төсвийг 2019 онд 700,000,000 төгрөгөөр батлуулан, 496,325,696.0 төгрөгийн санхүүжилтийг олгосон. Төлөвлөгөөт оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан. | 100 |
| Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын хүрээнд хэрэгжүүлэх төслийн тоо | 1 | МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКазУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2019 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр 2019.02.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2019.05.03-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 4-р шат буюу "Их Алтай"-н ажлын суурин боловсруулалтын ажил эхэлсэн бөгөөд Монголын тал Монгол Алтай хэмжээнд судалгааны ажлыг эхэлсэн. Төслийн ажилд 2019 онд 281,738,001 төгрөгийн төсвийг баталсан бөгөөд, 281,738,001.0 төгрөгийн санхүүжилт олгоод байна. Хамтарсан төслийн 17-р ажлын уулзалтыг Улаанбаатар хотноо 8-р сард зохион байгуулсан. Төслийн 2019 оны судалгааны ажлын анхдагч материалыг 2019.11.22-нд хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үндэсний геологийн албыг байгуулах ажлын явц, хувиар | 100 | | Үндэсний геологийн алба байгуулах тухай танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулахаар өөрчлөн зохион байгуулах байгууллагуудын танилцуулга, УИХ-ын тогтоолын төсөл, төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан, чиг үүргийн ангиллын тайлан болон холбогдох бусад материалыг ЗГХЭГ-т 2019 оны 01/2870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2019.10.16-ны өдрийн хуралдаанаар тус асуудлыг хэлэлцэн дэмжиж, асуудлыг УИХ-д өргөн мэдүүлэхээр холбогдох хууль, тогтоомжийн дагуу СЯ, ХЗДХЯ-аас зөвшөөрөл, ҮХГ, ТАЗ-өөс санал авч, тогтоолын үзэл баримтлалыг батлуулсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч УИХ-д өргөн мэдүүлсэн. | 100 |
| 5.3 | МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24 дэх заалт | Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын явц, хувиар | 60 | 2400 Хувийн хөрөнгө оруулалт | Далд уурхайн бүтээн байгуулалтын үйлдвэрлэлийн 2 дугаар босоо амыг барьж дуусгасан ба далд уурхайн хөндлөн малталт -30,923 экв.м3, налуу буюу конвейрийн малталт -8.299 экв.м3, босоо ам 3–нэвтрэлтийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж байна.<br>босоо ам 4 -нэвтрэлтийн цамхаг барих ажил явагдаж байна. 2019 оны нийт хөрөнгө оруулалт - 1,125,207,793 ам.доллар | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тавантолгойн орд ашиглалтыг өргөжүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын явц, хувиар | 20 | 380 Хувийн хөрөнгө оруулалт | Тавантолгой ордын талбайн ашиглалтыг өргөжүүлэх, нөөцийн хэмжээг нарийвчлан тогтоох, уурхайн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгын хүрээнд Тавантолгойн ордын талбайд хайгуул, өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэж байна. 2018 оны хөрөнгө оруулалтын төсвийн он дамжиж Тавантолгой ордын Цанхийн хэсгийн ашиглалтын хайгуулын ажилд 2.02 тэрбум төгрөг, Тавантолгой ордын Бортээг болон Оорцогийн хэсгийн нарийвчилсан хайгуулын ажилд 15.22 тэрбум төгрөг, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж гэр хорооллын 220 мянган айл, өрхийг шахмал түлшээр бүрэн хангах "Тавантолгой түлш" ХХК-тай гэрээ байгуулан гэрээний дагуу 111.76 тэрбум төгрөг, ЗГ-ын шийдвэрийн дагуу "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад 357.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.<br>Тавантолгойн нүүрсний уурхайгаас 27.6 сая тонн нүүрс олборлон 22.2 сая тонн нүүрс экспортолсон байна. | 100 |
| 5.4. | МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, 4, ЗГҮАХ-ийн 2.70-2.73 дахь заалт | Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн ажлын явц, хувиар | 50 | 250 Хөгжлийн банк | Монгол Улсын Засгийн газрын 2018.01.02-ны өдрийн 2 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барихад шаардлагатай гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөгөө болох "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18,2 км урт цахилгаан хангамжийн 110 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16,63 км урт хатуу хучилттай автозамын ажлыг эхлүүлж, түүнд шаардлагатай хөрөнгийг Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэхийг холбогдох сайд нарт даалгасан. Энэхүү шийдвэрийн дагуу дэд бүтцийн барилга угсралтын ажлыг 2018 оны 6 дугаар сард Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт эхлүүлж 2019.10.08-ний өдөр ашиглалтад хүлээн авсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
